

УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2024.03.01-2024.03.29 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ

Тайлангийн дугаар: Хяналт/2024/08

Хэвлэсэн огноо: 2024.04.02

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио нэвтрүүлэх станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг мөрдүүлэх зорилготой.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2024.03.01- 2024.03.29	СБД-ийн 6-р хорооны ХХЗХ- ны төв оффисын дээвэрт байрлах суурин хяналтын станц	47°55'39.21"N 106°54'53.20"E



Зураг 1. Хэмжилт хийсэн FMS-2014 суурин хяналтын станцын байршил

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2014 суурин хяналтын станц /CN01162391/


4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Ж.Дөлгөөн	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер
2	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:



Зураг 2. Радио давтамжийн 88 МГц-108.0 МГц-ийн зурвасын хэмжилт

7. Хэмжилтийн дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 34 хуулийн этгээдийн FM радиогийн нэвтрүүлэх станцуудад 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 29-ний өдрүүдэд суурин хяналтыг хийж гүйцэтгэлээ. Тус хяналтаар 9 FM радиогийн нэвтрүүлэх станцын давтамжийн хазайлтын максимум утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, 2 FM радиогийн нэвтрүүлэх станц үйл ажиллагаагаа түр зогсоосон, 23 FM радиогийн нэвтрүүлэх станц хэвийн ажиллаж байгаа нь тогтоогдлоо.


7.1 Үйл ажиллагаагаа түр зогсоосон:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
2	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	22800106	98.5


7.2 Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангаж үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Эм Жи Эл Радио ньус ХХК	22800192	88.3
2	Сета тех ХХК	22800193	89.3
3	Жавзандамба хутагт төв ТББ	22800186	89.7
4	Монгол комикс ХХК	22800159	91.1
5	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
6	Шүхэр ТББ	22800117	95.1
7	Авторадио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
8	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
9	МБШТГ	22800071	97.5
10	Радиоком Монгол ХХК	22800028	98.1
11	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
12	Нью медиа ХХК	22800024	99.3
13	Дижитал радио ХХК	22800060	99.7
14	РФ ХХК	22800005	100.1
15	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
16	Бадруун ХХК	22800006	102.5
17	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22800044	103.1
18	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
19	Чугу ХХК	22800037	105.5
20	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22800044	106.0
21	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6
22	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
23	Билэг санаа ХХК	22800018	107.5



Зураг 3. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын хэмжилтийн үр дүн




Зураг 4. Хэрэглэх зурвасын өргөний хэмжилтийн үр дүн

7.3 Стандартын шаардлагыг хангаагүй:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн хуулийн этгээдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	СКОД ХХК	22800167	88.8
2	Улаанбаатар телевиз ХХК	22800178	90.5
3	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
4	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол ТББ	22800097	95.7
5	РФ ХХК	22800005	100.5
6	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	100.9
7	Агрегатор ХХК	22800022	101.7
8	Медиа холдинг ХХК	22800009	103.6
9	Ви Өү Эм ХХК	22800052	104.0



Зураг 5. Давтамжийн хазайлтын максимум утгын хэмжилтийн үр дүн

8. Дүгнэлт:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангахгүй байгаа шалтгаан нь тухайн радиогийн нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тохиргооноос хамаарч байна. Иймд радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабель (фидер кабел, аудио кабел)-д тогтмол техникийн хяналт, үзлэг, үйлчилгээ хийж байх, студийн дууны холигч пультакны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.